



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

“БНБУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлд хамрагдаж техник, тоног төхөөрөмж худалдан авсан 4 иргэн, аж ахуйн нэгж 77.9 мянган еврогийн зээлээ гэрээнд заасан хуваарийн дагуу төлөөгүй байна”

Аудитын тайланг хүргүүлсэн:

Аймгийн ИТХ болон Засаг дарга тус тус хүргүүлсэн.

Дархан-уул аймаг

2023 оны 08 дугаар сар

**Аудитын
зорилго,
зорилтууд**

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх
- Хандивлагч орон олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжтэй эсэх
- Зээл тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аудитад аймаг, сумдын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Ургамал, газар тариалангийн хүрээлэн болон хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад, зээл тусламжийн хөрөнгөөр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, төслийн нэгж байгууллагын 2016-2022 оны хугацаан дахь зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг хамруулан гүйцэтгэлээ.

**Аудит хийхэд
гарсан
хүндрэл
бэрхшээл**

Аудитад хүндрэл бэрхшээл гараагүй болно.

А.2 БНБУ-ийн хөнгөлөлттэй зээлээр трактор худалдан авсан 2 аж ахуйн нэгж, 2 иргэн зээлийн төлбөрийг графикайн дагуу төлөөгүй байна

А.2.1. Хөнгөлөлттэй зээлд 11 аж ахуйн нэгж, 5 иргэн хамрагдаж 10,327.3 сая төгрөгийн зээл авчээ

1.2.1.1 Дархан-Уул аймагт хөдөө аж ахуйн чиглэлээр Азийн хөгжлийн банк болон Японы хамтын ажиллагааны Жайка байгууллагын санхүүжилтээр 3 төсөлд 6 аж ахуйн нэгжид 8,633.0 сая төгрөгийн зээл олгогдсон бөгөөд хугацаа хэтэрсэн зээл байхгүй, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлт хийгджээ.

Хүснэгт 1. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан ААНБ

(сая төгрөгөөр)

№	Төслийн нэр	Зээл авсан иргэн, ААН	Санхүүжилтийн эх үүсвэр	Зээл олгосон банк	Олгосон зээлийн дүн
1	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл	Дархан Эрдэнэ Мах комбинат ХХК	Азийн хөгжлийн банк	Капитрон банк	2,000.0
2		Өглөгчийн хэрэм ХХК		Төрийн банк	650.0
3		Газар өгөөж ХХК		Төрийн банк	950.0
4	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төсөл	Дархан Нэхий ХХК	Азийн хөгжлийн банк	Голомт банк	4,100.0
5		Дархан цасхан сүү		Голомт банк	700.0
6	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах Хоёр үе шаттай зээлийн төсөл	Эм Эн Эй Си ХХК	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/	Хаан банк	233.0
Дүн					8,633.0

1.2.1.2. “Газар өгөөж” ХХК зээлээ хугацаанаас нь өмнө хааж, 6 аж ахуй нэгж, байгууллага нь зээлийн эргэн төлөлтийн графикайн дагуу хугацаанд нь төлсөн байна. Зээл авсан ААН-үүд зээлийг гэрээнд заасан зориулалтын дагуу буюу үйлдвэрлэлийн байр барих, техник тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгө бэлтгэх зэрэгт зарцуулжээ.

1.2.1.3. Харин Бүгд найрамдах Беларусь улсын хөнгөлөлттэй зээлд Дархан-Уул аймгаас 10 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж нийт 510.3 мянган евро буюу 1,694.3 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг жилийн 1.37 хувийн хүүтэй, жилд 1 төлөлт хийх нөхцөлтэй авчээ. Гэвч 2 иргэн, 2 аж ахуйн нэгж зээлийн төлбөрийг гэрээнд заасан графикайн дагуу төлөөгүй байна.

№	Төслийн нэр	Зээл авсан иргэн, ААН	Цэвэр зээлийн дүн	Зээлийн хугацаа		Үүнээс		Зөрүү
				Төлж эхлэх	Төлж дуусах	Төлбөл зохих	Төлсөн	
1	БНБУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд техник, тоног төхөөрөмж	Б.Амангелди	20,352.0	2022.09.15	2024.09.15	7,062.8	7,834.4	-
2		Баттулга	8,470.0	2023.10.17	2025.10.17	-	-	-
3		Дархан-Уул аймгийн ХХААГ	244,340.0	2022.09.14	2024.09.14	59,355.9	-	(59,356.0)
4		Мягмарсүрэн	21,388.3	2022.11.17	2024.11.17	7,514.4	1,635.3	(5,879.1)
5		Оюут нарс агро	28,819.0	2022.09.08	2024.09.08	10,001.2	-	(10,001.2)
6		Пуужинт сум ХХК	21,653.1	2022.09.09	2024.09.09	7,514.4	10,831.1	3,316.7
7		Түвшинсайхан моторс ХХК	21,653.1	2022.09.14	2024.09.14	7,514.4	7,514.4	-
8		Түмэн буудай ХХК	24,850.0	2023.10.17	2025.10.17	-	-	-
9		Цэцэгмаа	23,744.0	2022.09.15	2024.09.15	8,239.9	5,564.14	(2,675.7)
10		Эрдэнэтуяа	11,599.0	2022.09.02	2024.09.02	4,025.2	4,166.5	141.3

Тодруулбал Дархан-Уул аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар ХААДС-аас 244.3 мянган еврогийн трактор тоног төхөөрөмж авсан боловч зээлийн хуваарийн дагуу 2022 онд төлбөл зохих 59.4 мянга, еврог огт төлөөгүй байна. Мөн “Оюут нарс агро” ХХК 10.0 мянган еврогийн төлөлтөө огт төлөөгүй байна. Харин Дархан сумын иргэн Ж.Мягмарсүрэн 5.9 мянга, Шарын гол сумын иргэн О.Цэцэгмаа 2.6 мянган еврогийн төлөлт дутуу хийсэн зөрчил илэрлээ. Энэ нь ХААДС-аас худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээний 5.3-д заасан хариуцлага тооцоогүйтэй холбоотой байна.

А.2.2. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгж нь зээлийн хөрөнгөөр техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийжээ

1.2.2.1. Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор доорх 3 компанид нийт 3,600.0 сая, Хөдөө аж ахуйн, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төслөөс 2 компанид нийт 4,800.0 сая төгрөгийн зээл тус тус олгогдсон бөгөөд зээлийн ашиглалтыг үзэхэд:

- “Дархан эрдэнэ мах комбинат” ХХК, “Өглөгчийн хэрэм” ХХК, “Газар өгөөж” ХХК-ууд эргэлтийн хөрөнгө бэлтгэх, хөргөлттэй агуулах барих, трактор техник тоног төхөөрөмж худалдан авах
- “Дархан нэхий” ХХК, “Дархан цасхан сүү” ХХК-ууд түүхий эд татан төвлөрүүлэх суваг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж шинэчлэх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэргийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Б.1.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл нь Монгол Улсын Хөгжлийн бодлоготой нийцэж байна.

2.1.1.1 Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллах гэрээг байгуулжээ. Төслийн зорилго нь хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг бэхжүүлэх, хүнсний ногоо тариалагч иргэн, хуулийн этгээдийг дэмжиж хүнсний ногооны ажлыг механикжуулах, дуслын усалгааны технологи нэвтрүүлэх, механикжсан зоорь, өвөл, зуны хүлэмжийн тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалалтыг дэмжиж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах юм.

Дээрх төсөл нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн Газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, зорилт, арга хэмжээтэй уялдсан байна.

Б.1.2. Тусламжаар ирүүлсэн хөрөнгө нь сумын иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж байна

2.1.2.1 “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах МОН-9192” төсөлд Дархан-Уул аймгийн Орхон сумын 70 өрх хамрагдсан бөгөөд төсөл хамрагдсанаар хүлэмж, тоног төхөөрөмжтэй болсноор өрхийн орлого нэмэгдсэн, хоршиж ажиллах нөхцөл бүрдсэн зэрэг үр өгөөжөө өгсөн

байна. Тухайлбал төсөлд хамрагдсан өрхүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад оролцогчдын 96.8 хувь нь өрхийн амьжиргаа сайжирсан гэж хариулжээ.

Харин тус төслийн хүрээнд хүнсний ногоо боловсруулах, савлах цех болон 150 тонны хамтын эзэмшлийн хүнсний ногооны агуулах барих ажил хугацаандаа хэрэгжиж дуусаагүйгээс хоршоодын хүнсний ногооны боловсруулах, хадгалах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаагүй байна.

Б.2 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 төсөл хугацаандаа хэрэгжиж дуусаагүй байна

Б.2.1 ХХААХҮЯ төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад гэрээнд заасны дагуу 1,535.9 сая төгрөгийн тусламжийн хөрөнгийг олгожээ

2.2.1.1. Азийн хөгжлийн банкнаас “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах МОН-9192” төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн Орхон сумын хүнсний ногооны үйл ажиллагааг өрхийн хэмжээнд эрхэлдэг 7 өрхийг дэмжих зорилгоор 7 нэр төрлийн 1,535.8 сая төгрөгийн тусламж өгсөн байна. Үүнд:

Хүснэгт 5. Дархан-Уул аймгийн Орхон суманд хэрэгжүүлсэн тусламжийн жагсаалт (2023 оны эхний хагас жилийн байдлаар)

(мянган төгрөг)

№	Тусламжийн төрөл	Хамрагдсан иргэн, ААН	Гэрээний дүн	Олгосон санхүүжилтийн дүн	Зөрүү	Хэрэгжилтийн хувь
1	Хүнсний ногоо боловсруулах, савлах цех	ГЭЭТ ХХК	953,563.6	667,494.5	(286,069.1)	70
2	150 тонны хамтын эзэмшлийн хүнсний ногооны агуулах	Смарт Грийн Девелопмент ХХК	537,923.4	376,546.4	(161,377.0)	70
3	Хүлэмжийн тоног төхөөрөмж	“Орхон шимт ногоон хөрс” хоршоо	29,742.0	29,742.0	-	100
4	Хүнсний ногоо боловсруулах цехийн тоног төхөөрөмж		-	261,491.6	-	100
5	Хүнсний ногооны худалдаа эрхлэх ТҮЦ		-	-	-	100
6	Хүлэмжийн тоног төхөөрөмж	“Газар шим өгөөж” хоршоо	200,603.0	200,603.0	-	100
7	Хүнсний ногооны худалдаа эрхлэх ТҮЦ		-	-	-	100
	Нийт дүн		1,721,832.0	1,535,877.5	(185,954.5)	91.4

Дээрх хүснэгтээс харахад хүнсний ногоо боловсруулах, савлах цех барих, 150 тонны хамтын эзэмшлийн хүнсний ногооны агуулах барих 2 ажил гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус ажлыг гүйцэтгэхээр тендерт шалгарч ХХААХҮЯ-тай гэрээ байгуулсан “ГЭЭТ” ХХК, “Смарт Грийн Девелопмент” ХХК-ууд гэрээний хугацааг сунгах хүсэлтийг яаманд хүргүүлсэн ч “ГЭЭТ” ХХК-ний хүсэлтийг хүлээн авч гэрээний хугацааг сунгаагүй байна.

Б.2.2 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 91.4 хувийн гүйцэтгэлтэй байна

2.2.2.1 Аудитаар дээрх тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа 2 ажлын гүйцэтгэлийг газар дээр очиж шалгахад “ГЭЭТ” ХХК-ний гүйцэтгэж байгаа “Хүнсний ногоо боловсруулах, савлах цех”-ийн ажил 70 хувийн гүйцэтгэлтэй, 261.5 сая төгрөгийн өртөгтэй цехийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн агуулахад хадгалагдаж байна, “Смарт Грийн Девелопмент” ХХК-ний гүйцэтгэж байгаа “150 тонны хамтын эзэмшлийн хүнсний ногооны агуулах”-ын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй байв.



2.2.2.2 Мөн “Орхон шимт ногоон хөрс”, “Газар шим өгөөж” хоршоо 70 өрхөд 230.3 сая төгрөгийн хүлэмжийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгснийг бүрэн ашиглаж байгаа бөгөөд, хэрэгжилт сайн байна. Гэвч тус төслийн хүрээнд хүнсний ногоо худалдаалах ТҮЦ-ийг “Орхон шимт ногоон хөрс”, “Газар шим өгөөж” хоршоодод олгосон ч холбогдох баримт материал, гэрээ байхгүй байсан.

2.2.2.3. Аймгийн ХХААГ-т тухайн орон нутагт хэрэгжиж буй зээл, тусламжийн талаарх мэдээлэл байхгүй байгаа нь холбогдох яам, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай харилцан уялдаатай ажилладаггүйтэй холбоотой байна. Энэ нь зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, гэрээний үүргийн биелэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- БНБУ-ийн хөнгөлөлттэй зээлээр трактор худалдан авсан 2 аж ахуйн нэгж, 2 иргэн зээлийн төлбөрийг графикайн дагуу хугацаанд нь бүрэн төлөөгүй байгаа нь худалдагч талаас худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох арга хэмжээ аваагүйтэй холбоотой байна.
- Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж зээлийн хөрөнгөөр эргэлтийн хөрөнгө бэлтгэж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна.
- Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл нь Монгол Улсын Хөгжлийн бодлоготой нийцэж байна.
- Тусламжаар ирүүлсэн хөрөнгө нь сумын иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж байна
- Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 төсөл хугацаандаа хэрэгжиж дуусаагүй байна
- ХХААХҮЯ төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад гэрээнд заасны дагуу 1,535.9 сая төгрөгийн тусламжийн хөрөнгийг олгожээ
- Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 91.4 хувийн гүйцэтгэлтэй байна

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

- Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах зөвлөмжийг Хөдөө аж ахуйг дэмжих санд хүргүүлэх;
- Гэрээний үүргээ биелүүлээгүй 2 иргэн, 2 аж ахуйн нэгжээр 77.9 мянган еврогийн зээлийн төлбөрийг төлүүлэх хугацаатай албан шаардлага хүргүүлж, холбогдох арга хэмжээг авах

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
2023.08.16